

ТҮҮХ, СОЁЛ

Д. Базаргарьд

**ХЯТАДЫН ТҮРЭМГИЙЛЛИЙН
ХӨНӨӨЛТ УЛАМЖЛАЛ**

Бээжингийн эрх баригчдын их гүрний эзлэн жанжлах стратегийн зорилго, энх тайван, социализмыг илт дайсагнагч үйл ажиллагааны оргил нь энэ оны хоёрдугаар сард Вьетнамын эсрэг өдүүлсэн түрэмгий дайн, Зүүн өмнөд Азид социализмын байр суурь бэхжихэд саад тотгор учруулах хорон санааны үүднээс энэ районы тусгаар тогтносон улс орнуудын эсрэг янз бүрийн хэлбэрээр шатлан үргэлжлүүлж буй Бээжингийн шившигт өдөөн хатгалга боллоо. Энэ нь Хятадын удирдагчдын санаа бодлын жинхэнэ тамирыг нэгмөсөн илчилж, дэлхийн олон нийтийн жигшил, зэвүүцлийг бадруулав. Үүний улмаас Вьетнамын эсрэг хятадын түрэмгийллийн мөн чанар, түүхэн үндсийг уудлан илчилсэн мэдээ материал, ном зохиол энэ хэдэн сарын дотор дэлхийн олон оронд гарлаа. Үүний дотроос зөвлөлтийн «Түүхийн асуудал» сэтгүүлийн энэ оны 6 дахь дугаарт Г. Ф. Мурашевын бичиж нийтлүүлсэн «Вьетнамын эсрэг өдүүлсэн хятадын түрэмгий дайнууд» гэсэн өгүүлэлд бээжингийн одоогийн эрх баригчдаас социалист Вьетнамын эсрэг өдүүлсэн түрэмгийлэл нь зорилго хийгээд арга хэлбэрээрээ эрт дээр цагт Хятадын болон манжийн эзэн хаадаас эрх чөлөө, үндэсний тусгаар тогтнолоо нандигнан эрхэмлэгч Вьетнам орныг эзлэн дагуулах зорилгоор удаа дараа явуулж байсан түрэмгий бодлого цуст дайныг бараг үсэгчлэн давтаж байгааг түүхийн хөдөлбөргүй баримтаар нотлон харуулжээ. Энэ нь хятадын одоогийн удирдагчдын жанжлан ноёрхох балмад чиг шугам бол эртний хятадын эзэн хаад, эзэрхэг цэргийн эрхтний явуулж байсан бодлогын шууд үргэлжлэл мөн болох тухай ах дүү коммунист, ажилчны намуудын дүгнэлтийг давхар баталж байна.

Х Х Х

Ази тивийг алсдаа дэлхий дахиныг ноёрхох анхны гишгүүр болгон Зүүн өмнөд Ази, юуны өмнө хятадын тэр балмад төлөвлөгөөг хэрэгжүүлэх замд ноцтой саад болж байгаа социалист Вьетнам улсыг эзлэн захирах алсын санаат бодлого явууллага, бүрэн эрхт тусгаар тогтносон улсыг «залхаах», «хашраах» гэдэг ихэмсэг танхай хандлага, хүн ардын амь насыг хайр найргүй бүрэлгэгч зэрлэг хэрцгий арга нь Бээжингийн дээд эрх баригчид дэлхийн-социализмын заналт дайсан болж хувирснаар үл барам Хятадад эртний феодалын милитарист үзэл санаа амилан сэргэж байгааг Г. Ф. Мурашев маш зөв тэмдэглэжээ.

Хятад улс дэлхий дээр ноёлох тавилантай бөгөөд их хятад үндэстэн бусад улс түмнийг давамгайлан ноёрхож байх ёстой гэдэг бурангуй үзэл Хятад оронд бүр дээр цагт үүсчээ. Хятад орон хэзээнээс нааш гадаад ертөнцөөс битүү хаалттай явж ирсний гадна тэнд бүрэлдэн үүссэн өвөрмөц соёл иргэншил нь яваандаа айл хөрш нилээд ард түмнийг хамран уусгасан буюу нэвтрэн нөлөөлсөн явдал их хан үндэстний дээрэнгүй ойлголт даамжрах үндэс хөрс болжээ. Тэр төөрөгдөл нь төвлөрсөн Хятад улс үүсч, газар нутаг, хүн амын хувьд Номхон далайн эрэг хавийн Азийн хамгийн

хүчирхэг, нөлөөтэй том орон болж хувирахын хамт бүр ч гаарчээ. Тэрхүү төөрөгдлийн үзэл суртлын илэрхийлэл нь Хятадын эзэн хаадыг тэнгэр язгууртан болгон дүрслэж, дэлхий ертөнцийг жанжлан ноёрхох явдлыг Хятад улсын «ердийн эрх» мэтээр номлогч Күнзийн үхширмэл сургаал байжээ. Уг сургаалыг бататгахад тэр үед Хятадын ойр хавьд түүнтэй эн зэрэгцэхүйц тийм хүчирхэг том улс байгаагүйн гадна бага жижиг орны эрх баригчид шороон түмэн хятадын аманд орж уусахгүйн тулд Хятадын хаадын нэр нөлөөг ёс төдий боловч хүндэтгэн үзэхэд хүрч байсан явдал бас тус дөхөм үзүүлжээ. Үүнээс үндэслэн Хятад улс аливаа бүхнийг дээрэнгүйлэн захирах ёстой гэдэг үзлийг хятадын ноёлогч ангийн төлөөлөгчид олон зуун жилийн турш бишрэн шүтэж, түүгээрээ хүн ардынхаа тархи толгойг цаг үргэлж мунхруулж иржээ.

Чухамхүү тэр их гүрний дээрэнгүй үзэл санааны шууд нөлөөгөөр феодалын төрийн уламжлалт гадаад бодлого бүрэлдэн үүсч, айл зэргэлдээ орны газар нутгийг эзлэн авах эрмэлзлэл түүний гол нэг чиглэл болжээ. Тэгээд хэзээ нэгэн цагт янз бүрийн шалтгаанаар хятад цэрэг, түшмэл, худалдаачин, тэр ч байтугай аль нэг хятад жуулчны хөл гишгэсэн газар бүхнийг хятадын уугуул нутаг хэмээн гүжирдэж, тэр нутгийг эзлэн авахыг санаархах явдал хятадын гадаад бодлогын гол зарчим болон хувирчээ. Тэр хэрцгий балмад уламжлалыг хятадын одоогийн эрх баригчид үргэлжлүүлж байгааг тэдний практик ажиллагаа харуулж байна.

Тэр харгис түрэмгий үзлийн үүднээс Хятад нь Вьетнамыг өөрийн өмнөд хязгаарын «албат харьяат» гэж үзсээр ирсэн бөгөөд тэр нь хятад-вьетнамын олон зуун жилийн харилцааны бүх шатанд гүнзгий ул мөрөө үлдээжээ.

Вьетнамын түүхчдийн тооцоолон гаргаснаар (1979 он хүртэлх) 2200 жилийн түүхэнд харийн түрэмгийлэгчдийн эсрэг 13 удаа эх орны дайн хийсний есийг нь хятадын булаан эзлэгчдийн эсрэг явуулжээ.

Одоогийн Вьетнамын (Вьетнам гэдэг нэрийг анх 1804 оноос хэрэглэх болжээ) өвөг дээдэс болох эртний вьетийн Ванланг улсыг манай эриний өмнөх VI—V зууны үед «Умарын орон» (Хятад) эзлэн дагуулах зорилгоор түрэмгийлж байжээ. Эртний хятадын Цинь улс (манай эриний өмнөх 221—206 он) үүсэн тогтсон цагаасаа Вьетийн уудам баялаг нутгийг халдан довтлох бодлогыг дэс дараатайгаар явуулж эхэлсэн бөгөөд Вьетнамын эсрэг анхны зохион байгуулалттай түрэмгийллийг хятадын эзэн хаан Цинь Шихуан хийжээ. Хятадын тулгуур бичигт өгүүлснээр хятадын 500 мянган цэрэг «гурван жил хуяг дуулга тайлалгүй, нумны хөвч сулруулалгүй» байлдсан боловч 214 онд хүнд ялагдал хүлээжээ. Тэгмэгц Цинь Шихуан нэмэлт хүч дайчилж, олон жил байлдсаны эцэст вьетнамын эх орончдын эсэргүүцлийг дарж, түүний нийслэл Колоаг хотыг эзэлжээ. Хятадууд эзэлсэн нутгийг Гуйлинь, Наньхай, Сян гэдэг гурван тойрог болгон хувааж, хятад засаг захиргаа байгуулан, олон тооны нүүдэлчин хятадуудыг оруулж вьетнамын газар шороог «цаньши» хэмээх зарчим буюу айл хөршийн нутгийг мяндасны хүр хорхой мэт хэмлэн идэх аргаар эзэмшиж эхлэжээ.

Гэвч хятадын ялалт урт насласангүй. Төдхөн Вьетнамын шинэ захирагч Жао То (Чьеу Да) Хятадын Хан улсаас тусгаарлаж, биеэ даасан Намвьет улс байгуулжээ. Тэр улсын нутагт вьетнамын хойд хэсгээс гадна одоогийн хятадын Гуанси, Гуандун муж багтаж байжээ.

Гэтэл Баруун Хан улсын эзэн хаан У Ди Хятадын баруун өмнөд талд оршиж байсан бараг бүх овог аймгийг түрэмгийлэн эзэлжээ. Түүгээр ч барахгүй Хан улсын эзэн хаан Сюань Ди хан үндэстний шунахайран эзлэх бодлогыг хуульчлан бататгаж, «Хан улс нь дэлхийн бүх улсыг толгойлж, тэднийг хүчээр болон үнэнч байх ёсыг сахиулах аргаар захирч

байх болно. Нар, сарны дор амьдрагч бүхэн бол Хан улсын эзэн хааны зарц нар мөн... Дагаар орогсдыг хөхүүлэн шагнаж, эсэргүүцэн босогчдыг залхаан шийтгэнэ» гэдэг зарлиг буулгаж байжээ. Тэр зарчмыг хятадын эзэн хаад Вьетнамын эсрэг бодлогодоо хэлбэрэлтгүй баримталж байжээ.

Манай эриний өмнөх 112 онд эзэн хаан У Ди Намвьетын төв засаг суларч дотоодын хямрал хүчтэй болсныг далимдуулан өмнөд далайд хүрэх гарамтай болохын тулд 100 мянган цэрэг хөдөлгөж, Намвьетын нийслэл (одоогийн Гуанжоу) хотыг эзлэн, эзлэгдсэн нутгийг засаг захиргааны 9 тойрог болгон хувааж хүчээр хятадчилан уусгах бодлого явуулж эхэлжээ. Хятадууд үндэсний зан заншлыг өөрчилж хэрцгий догшин авирласан учир манай эриний 40 онд вьетнамын баатарлаг эх оронч эгч дүү Чынг Чак, Чынг Ньн хэмээх хоёр бүсгүйн удирдлагаар ардын бослого өрнөж, өргөн олон түмнийг нэгтгэн ахар богино хугацаанд 65 бэхлэлтийг эзэлж бараг бүх нутгаа чөлөөлөөд, Чынг Чак тэргүүтэй тусгаар улс байгуулжээ. Гэтэл хятадын Хан улс 43 онд их цэрэг илгээж, вьетнамын ардын бослогыг зэрлэгээр харгислан дарж 40 мянган вьетнамчуудын амь насыг сүйтгэжээ. Энэ тулалдаанд хоёр эх оронч бүсгүй баатарлагаар амь үрэгдсэн боловч тэдний яруу сайхан үлгэр дууриал нь ард түмнээ харийн булаан эзлэгчдийн эсрэг тэмцэлд үеийн үед зоригжуулсаар иржээ. Тэр хоёр бүсгүйн удирдсан ардын бослого нь вьетнамын ард түмэн эх орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэх шантрашгүй хатан зоригтойг харуулаад зогсоогүй, бага жижиг орны ард түмний хувь заяагаар наадахыг эрмэлзэгч хятадын булаан эзлэгчдэд улс төрийн том цохилт болжээ. Тэр цагаас эхлэн Вьетнамын умард хэсэг Х зуун хүртэл хятадын янз бүрийн хаадын түрэмгийлэлд удаа дараа хэлмэгдэж байсан боловч эрх чөлөөний тэмцэл тасралтгүй үргэлжилсээр байжээ.

544 онд цэргийн түшмэл Ли Бон тэргүүлэн босч, хятадын амбан сайдыг нутгаасаа хөөн зайлуулж, мөн 603 онд Вансуан хэмээх биеэ даасан улс байгуулжээ. Гэтэл түүнийг Хятадын Суй улс эзэлжээ. Ийнхүү Вьетнам орон Хятадын Тан улсын (68—907) эрхшээлд дахин оржээ.

Харин Тан улсын төр мөхөж дотоодын самуун эхлэхэд Вьетнамын цэргийн жанжин Нго Кюен умард Хан улсын цэргийг ялж, 939 онд Вьетнамын тусгаар тогтнолыг тунхаглаж улс орноо харийн булаан эзлэгчдийн мянга шахам жилийн ноёрхлоос чөлөөлсөн нь Вьетнам-Хятадын харилцааны түүхийн шинэ хуудсыг нээжээ.

Гэтэл хятадын шинэ Сун улсын (960—1279) эзэд Вьетнам орон Хятадаас тусгаарласанд хорсож, тэнд үүсэн тогтсон хүчирхэг Дайковьет улсыг эзлэн түрэмгийлэх явдлыг өөрийн тэргүүн зорилт болгон тавьжээ. Сун улсын эзэн хаан Тай Зун Дайковьетэд явуулсан нэгэн зарлигтаа: «Хятад ба түүний эргэн тойронд орших зэрлэгүүд бол хүний гар, хөлийн адил нэгдмэл нэг бие махбодь юм. Бүх хөдөлгөөн зүрхнээс эхлэдэг учраас түүнийг анхаарах нь гол. Цусны судсанд ямар нэг гэмтэл гарвал гар, хөл хөдлөхөө больж эм уух хэрэгтэй болдог. Хэрэв эм тус болохгүй бол зүү тавиулж, төөнүүлэх хэрэгтэй. Тэгвэл бүх бие махбодийн систем хэвийн байдалдаа орно. Хэдийгээр эм уухад ам гашуу оргиж, зүү тавихад арьс мах язрах боловч ач тус нь учрах шаналгаанаас хамаагүй илүү байдаг. Тэнгэрийн эзэн хаан чухамхүү ингэж айлддаг бөгөөд зэрлэгүүдийг өвчилснийг мэдээд Кинь (Одоогийн Хубей муж, Тхук (Сычуань), Тыонг Дам (Хунань) газрыг эм уу, Куанг-вьет (Гуанси, Гуандун), Нго болон Со (Аньхой) газрыг зүү тавиулж, төөнүүл гэж зарлиг буулгаж ёсоор гүйцэтгэсний ачаар бүх бие махбодь нь засарсан юм. ...Цзяожи (Вьетнамыг хятадууд тэгж нэрлэдэг байжээ) хэдийгээр хятадын ойрын харьяат нарын тоонд ордоггүй боловч түүнийг бид хятадын бие махбодийн хэсэг гэж

үздэг. Түүнийг жишээлбэл эзэн хааны гарын хуруутай адилтгаж болно. Хэрэв тэр хуруу нь өвдөөд байвал эзэн хаан хуруугаа эмчлэхийг бодно» гэж бичжээ. Ийнхүү хятадын эзэн хаад Дайковьетийн (Вьетнамын) өвчин бол Хятадын бүрэлдэхүүнээс гарч, өөрийнхөө зан заншил, хууль ёсыг баримтлах гэсэн явдал гэж үзэж байжээ. Ингэхлээр «тэр нутгийн эздийг хятадын соёлоор сэнхэрүүлж гэгээрүүлэх хэрэгтэй. Хэрэв тэр захирагдах гүй бол бид шийдвэртэй цохилт өгөхөөр завь, онгоц, хэнгэрэг цан, морин ба явган цэргээ бэлэн байлгах болно» гэж, уг захидлын төгсгөлд бичжээ. Энэ нь «алдагдсан вьетнам нутгийг» буцаан эзлэхээр тэр үед Хятад орон ид хийгдэж байсан кампанийн үзэл суртлын бэлтгэл байжээ. Удсан ч үгүй 981 оны эхээр Сун улсын цэрэг далай болон хуурай замаар Вьетнамд цөмрөн оржээ. Лангшоны чиглэлээр довтолсон хуурай замын арми, Батьданг голын чиглэлээр хөдөлсөн усан флот нь цаашдаа нийлж тэр үеийн Вьетнамын нийслэл Хоал хэмээх бэхлэлтийг бүслэх ёстой байжээ. Гэтэл авьяаслаг жанжин Ле Хоанаар удирдуулсан вьетнамын цэрэг чадамгай байлдаж хүчтэй эсэргүүцсэн учраас Сун улсын цэрэг ихээхэн хохирол хүлээж, усан замын хүчтэйгээ нийлэлцэж чадаагүй ажээ. Довтолгоон мухардалд орж, Сун улс арга буюу байлдааны ажиллагааг зогсооход хүрчээ. Гэсэн ч хятадын түрэмгийлэгчид шунахай санаагаа орхиогүй ажээ.

Хятадын умард, баруун хойд талаас Ляо, Ся улсууд заналхийлж, дотоодод тариачдын бослого дэгдсэн XI зууны 60-аад оны үед хятадын эрх баригчид өмнө зүг түрэмгий дайн хийх замаар дотоод, гадаад хүнд байдлаас мултрах арга замыг хайж байжээ. Тэд шинэ түрэмгийлэлд бэлтгэхдээ «эхлээд өмнө зүг, дараа нь умар зүг» гэдэг стратегийг мөрдлөг болгож байжээ. Үүнтэй холбогдуулан хятадын шинэчлэх үзэлтэн Ван Аньши: «Манай арми Цзяожийг (Вьетнамыг) бут цохисноор манай нэр хүнд дээшилнэ. Тэгмэгц бид Шэньсид ялалт байгуулахаа өөрөөр хэлбэл Ся улсын цэргийг ялахаа мэдээлнэ. Тэр нь Шэньси дахь манай арми болон хүн амын сэтгэл санааг сэргээнэ. Энэ нь Ся улсыг нэгмөсөн залгих бололцоог бидэнд өгнө. Хэрэв бид Ся улсыг залгивал Хятадыг сандаргах хэн байх билээ» гэж хэлж байжээ. Мөнгөн санхүүгийн хүнд гачигдалд учирсан үед Вьетнамыг довтолохоор бэлтгэхдээ хятадууд Дайвьетын алтны баялагтай нутаг буюу одоогийн Вьетнамын Каобанг мужийг юуны өмнө эзлэн авах зорилго тавьж байжээ. Уг түрэмгийллээ баттай болгохын тулд Сун улсын дипломатууд эртний «ии жи и» («нэг бүдүүлгийг нөгөөгөөр нь даруулах») тактик хэрэглэж Вьетнамын эсрэг эвсэл холбоотон олохын тулд Дайвьетын өмнөд хөрш-Тьямпу, Ченла (Кампучид) элч төлөөлөгч томилон явуулж байжээ. Үүний зэрэгцээгээр хятад-вьетнамын хилийн дагуу орших овог аймгийн удирдагчдыг элдэвлэн ятгаж, тэднийг өөртөө татаж вьетнамын эсрэг дайнд ашиглах ажлыг идэвхтэй зохиож, Вьетнамын хилийн орчим цэрэг бөөгнөрүүлэн, хүнс, тэжээл, хөсөг тээвэр нөөцөлж, байлдааны бэлтгэл сургууль хийдэг болжээ. Энэ бүх нь мянга гаруй жилийн тэртээ болж байсан боловч 1979 онд; болсон хэрэг, уг явдлыг бараг тэр аяар нь санагдуулж байгаа нь хэн бүхэнд илт байна,

Ийм нөхцөлд Вьетнамын тал хятадын их хэмжээний түрэмгийллийг урьдчилан няцаахаар шийдвэрлэж, 1075 оны аравдугаар сард давшилтанд орж, дайсны цэргийн гол хүчний төвлөрч байсан Юнжоу бэхлэлтийг эзлэн сүйтгэжээ. Байдал ийм болмогц Сун улсын эрх баригчид «өш хонзон авах цохилт» хийх нэрийн дор 100 мянган явган цэрэг, 10 мянган морьт цэрэг, 200 мянган зөөгчид дайчилж, хуурай замын армийг дэмжих тэнгисийн цэргийн их хүчнийг бөөгнөрүүлжээ. Довтолгоон эхлэхийн өмнөхөн 1076 оны нэгдүгээр сард Сун улсын эзэн хаан зарлиг буулгаж, Вьетнамыг «Хятадын хязгаар нутаг» гэж зарлаад, «Биднээс ард түмэн та бүхэнд хандаж хэлэхэд: хэрэв та нар эзэн захирагчаа Хятадтай нэгдэхийг ятгахгүй бол нялц даруулж, хүнд зовлон эдлэх болно. Хэрэв тэр өөрөө

ард түмнээ толгойлон эргэн ирж бидэнд дагаар орж хүчин зүтгэвэл түүний байнга авдаг хэргэм, пүнлүүг хоёр дахин нэмэгдүүлж, урьд үйлдсэн гэм ялыг дагууд нь цагаатгана...» гэж амлажээ.

Ингээд 1076 оны хуучаар Сун улсын арми хэд хэдэн чиглэлээр Вьетнамын нутагт цөмрөн орсон боловч ширүүн дайнаар хурдан ялах гэсэн дайсны тооцоо баларчээ. Вьетнамын чөлөөлөх дайныг хил орчмын овог аймгийн удирдагчид болон үндэсний цөөнхийн хүн ам идэвхтэй дэмжжээ. Хятадын цэргийн хүч дорхноо суларч, ар талаасаа холдож тасарсан учир зэр зэвсэг, хүнс хоолны хүнд гачигдалд учирчээ. Хүний нутагт гурван сар байлдахдаа хятадын тал цэргийнхээ тэн хагасыг алдаж, үлдсэн хэсэг нь хижиг томуунд нэрвэгджээ. Ийм нөхцөлд Сун улс байлдааныг зогсоох тухай Вьетнамын талын саналыг арга буюу зөвшөөрөхөд хүрчээ. Вьетнамыг номхотгон захирах гэсэн түрэмгийлэл Хятадад хэмжээлшгүй хүнд их гарз хохирол болжээ. Цэрэг дайны зардал 5, 19 сая лан алт болсны дээр дайнд мордсон 100 гаруй мянган цэргээс дөнгөж 26500 гаруйхан хүн амьд мэнд буцжээ. Дайнд алагдсан, өвчнөөр үхсэн цэрэг, зөөгчдийн тоо 300 мянгад хүрчээ.

Вьетнамын ялалтын гол үр дүн нь тэр цагаас хойш хятадын Сун улс 200 гаруй жилийн турш Вьетнамд зориглон халдаагүй бөгөөд 1164 онд Вьетнамын тусгаар тогтнолыг арга буюу хүлээн зөвшөөрч, түүнийг хятадаар Цзяожи гэж нэрлэдэг байсныг өөрчилж, «Аньнанийн Вант улс» гэж нэрлэх болсон явдал байжээ.

Юан гүрний үед хятадын зэвсэгт хүчин Вьетнамд (1258, 1285, 1287—88 онд) гурван удаа халдсан боловч тухай бүр няцаагджээ. Их Юаний дараа үүссэн Мин улс (1368—1644) Вьетнамыг мөн л хятадын «уугуул нутаг», «үүрдийн албат» гэж үзэж байлаа. 1370 онд Мин улсын эзэн хаан Чжу Юаньчжан Вьетнамыг Хятад улсын хүрээнд багтаан оруулах оролдлого хийж, тусгай зарлигаар Вьетнамын бүх уул, усыг Хятадын онгон тахилгат уул, усны тоонд оруулж, хятадын газрын зураг дээр тэмдэглүүлж байжээ. Тэр өнгөлзлөг нь сүүлдээ бодит түрэмгийлэл болон хувирч, 1406 оны арван нэгдүгээр сард Мин улс Вьетнамын вангийн ширээнд өөрсдийн талын этгээдийг суулгах зорилгоор дотоод хэрэгт нь хөндлөнгөөс оролцож 200 мянган цэрэг, хэдэн зуун мянган зөөгчид бүхий, их хүчээр довтлон оржээ. Хятадын булаан эзлэгчид умард Вьетнамыг хятадын засаг захиргааны нэгж болгон нийлүүлж, Дайвьет хэмээх хуучин нэрийг өөрчлөн дахин Цзяожи тойрог гэж нэрлээд тойргийн засаг захиргааны аппаратын гол тушаалыг хятадууд эзэлжээ. Түүнчилэн эзэлсэн нутагт цэргийн хатуу хяналт хүнд бэрх албан татварын систем тогтоож, давсны худалдааг монопольчилж, хүн ардыг хүнд хэцүү хөдөлмөрт зүтгүүлж эхлэсний гадна олон тооны шилдэг урчуудыг Хятад нутагт албадан аваачжээ. Энэ бүхэн нь вьетнамын үндэсний соёлыг устгах, зан заншлыг өөрчлөх, вьетнамчуудыг хүчээр уусгах арга хэмжээтэй хослон явагдаж байжээ.

1418 оны хоёрдугаар сард үндэсний уламжлалт цагаан сар Тетийн баярын өдөр төрийн нэрт зүтгэлтэн Ле Лой (Ле Тхай То) Ламшон хэмээх газар бослого дэгдээн, булаан эзлэгчдийн давуу хүчтэй тулалджээ. Ардын бослогыг дарахаар Мин улсын арми 100 мянган цэрэг дайчилсан боловч босогчдыг өргөн олон түмэн дэмжиж Вьетнамын бараг бүх нутгийг хамарсан партизаны дайн өрнөжээ. Байдал ийм болмогц Мин улс нэгдүгээрт Хятадын умарт хилийн байдлыг төвхнүүлэн тохинуулах, хоёрдугаарт вьетнамчуудын эсэргүүцлийг дарах хүч хуримтлуулах, гуравдугаарт, вьетнамын эзлэгдсэн нутгийн байгалийн баялаг, юуны өмнө үнэт металлыг олзворлон ашиглахын тулд залхаан цээрлүүлэх байлдааны ажиллагаагаа 1423—24 онд түр завсарлажээ. Тэр хугацаанд вьетнамын

партизаныуд тэмцлээ үргэлжлүүлэн, зарим хот, тосгодыг чөлөөлж, ирээдүйн шийдвэрлэх тулалдаанд бэлтгэж байжээ.

1426 оны 11 дүгээр сард хятадын 50 мянган цэрэг бүхий нэмэлт хүч хүрэлцэн очсон боловч тус болсонгүй. Ламшоны босогчид хятадын цэргийг хиар цохиж, одоогийн Ханойн хавилцаа болсон нэг удаагийн тулалдаанаар дайсны 60 мянган цэргийг устгажээ. Тэгээд хятадын булаан эзлэгчид нутгаасаа шинэ хүч нэмж ирүүлэхэд цаг хожих зорилгоор найрамдлын хэлэлцээ хийх санал тавьжээ.

1424 онд хятадууд 150 мянган цэрэг бүхий хоёр армийг шинээр нэмж аваачихад нь вьетнамын босогчдын гол хүч хятадын 100 мянган цэрэгтэй нэгдүгээр армийг хуурч дагуулан байлдсаар Тьилангийн хавцалд оруулж бут цохиод командлагчийг нь олзолжээ. Дайсны бусад хүч нь Сыонг Зянг хэмээх бэхлэлтийн хавилцаа мөн бут цохигдож, командлах бүх бүрэлдэхүүн нь олзлогджээ.

Хятадын түрэмгий цэргийн ерөнхий командлагч Ван Тун Тханглонг (одоогийн Ханой) хотод үлдсэн цэрэгтэйгээ бүслэгдэж, арга буюу бууж өгчээ. Энэ нь Вьетнамын чөлөөлөх дайнд шийдвэрлэх ач холбогдолтой ялалт болжээ.

Үүгээр вьетнамын ард түмнийг тусгаар тогтнолын төлөө баатарлаг тэмцлийн бас нэг чухал үе шувтарчээ.

Манж Чин улсын (1644—1911) ноёрхлын үед манж-хятадын эрх баригчдын шунахайран эзлэх бодлогод Вьетнам дахин өртжээ.

XVIII зууны сүүлчээр бүх Вьетнам даяар дэгдсэн тариачдын бослогын үр дүнд дайчин хүчирхэг арми бүхий нэгдмэл том улс байгуулагджээ. Нийт Зүүн өмнөд Азид нөлөө бүхий биеэ даасан бодлоготой нэгдмэл хүчирхэг Вьетнам улс үүссэн явдалд хорссон хятадын эрх баригчид Вьетнам орны тусгаар тогтнолыг бүрэлгэх аливаа аян шалтгийг идэвхтэй хайж эхлэжээ. Тэд вьетнамын тариачдын бослогоор огцрогдсон эзэн хаантай нь хуйвалдаж Вьетнамд цэрэглэн халдах түрэмгий бодлогоо зөвтгөхийн тулд «Вьетнам бол Хятадын нутгийн салшгүй хэсэг байгаад алдагдсан юм» гэдэг сэдвийг дахин гаргаж иржээ. 200 мянган цэрэг, олон арван мянган зөөгчид зэрэг туслах хүчтэй Чин улсын их арми 1788 оны арван нэгдүгээр сард Лангшон, Каобанг, Гуанинь, Тюенкуангийн дөрвөн чиглэлээр довтолжээ. Ингэж довтолохын тул хятадууд Юньнань, Гуанси мужаас одоогийн Ханой хүртэлх хоёр замын дагуу цэргийн хоол хүнс, зэр зэвсэг дамжуулан тээх 70 өртөө байгуулсны гадна эзлэгдсэн нутагт дахиад 123 цэргийн өртөө байгуулж, 200 мянган зөөгч ажиллуулахаар төлөвлөж байжээ. Хятадууд цөмрөн орсон нутгийн энгийн номхон ард иргэд, хүүхэд, хөгшид, эмэгтэйчүүдийг хүйс тэмтрэн хядаж, тариаланг сүйтгэн, орон байшинг дээрэмдэж эхлэжээ.

Ийм аюул эх орныг дахин нөмрөхөд Вьетнамын эх орончид төв болон өмнөд мужууд дахь армийн хүчээ бэхжүүлэн 100 мянга хүртэл өргөжүүлж умар зүг шуурхай аялал хийж хятадын түрэмгийлэгчдэд шийдвэртэй цохилт өгөхөөр хөдөлжээ. 1789 онд одоогийн Ханой хотын дэргэд болсон тулалдаанаар Чин улсын армийг бут цохиж, асар их хохирол учруулсан явдал манж-хятадын түрэмгийлэгчдийн зоригийг мохоож, вьетнамын ард түмнийг хятадын жанжлагчдын өмнө сөхрүүлж чадахгүйг ойлгуулжээ. Тийм учраас Чин улсын тэнгэрийн тэтгэсэн эзэн хаан Цянь Лун: «Ань-нань бол алс хол орших аюултай газар юм... Түүнийг эзлэн захирахаар дахиад арми явуулбал тэр орныг номхотгон захирч байхын тулд тэнд асар их хэмжээний цэрэг байлгаж байх хэрэгтэй болно. Тэгэхгүй бол ард түмэн нь босч тэмцэнэ. Урьдах төрүүдийн үед Аньнань манай нутагт багтаж орж байсан боловч дандаа л бослогоор шувтардаг байв. Тэр газрыг одоо бид булаан авлаа ч гэсэн хэдэн жилийн дараа дахиад л тэд үймээн самуун дэгдээнэ» гэж хэлэхэд хүрчээ.

Вьетнамд феодалын хятадын олон зуун жилийн эзэрхийллийн түүх ийнхүү шившигтэйгээр төгсчээ.

XIX зууны эхээр Хятадын төр доройтож, удалгүй аж үйлдвэрийн өндөр хөгжилтэй өрнөдийн капиталист гүрнүүд, дараа нь Японы түрэмгийллийн бай болж хувирсан билээ. Гэтэл империалистуудын шахалт даралтын эсрэг тэмцэж байсан хятадын хөрөнгөтний үндсэрхэг үзэлтнүүд харийн булаан эзлэгчдийн эрхшээлээс ангижрах арга замыг хайхдаа айл хөрш орнуудыг хүчирхийлэн дарангуйлж байсан хятадын эрт дээр үеийн байдлыг сэргээж, эзэн хаадын жанжлан ноёрхох гадаад бодлогыг үргэлжлүүлэн явуулахыг эрмэлзэж байжээ. Ийнхүү Хятадын ноёлогч ангиудын тархи толгойд гүнээ шингэсэн Хятадын төвлөн захирах үзэл санаа нь шинэчлэгч үзэлт үндэсний хөрөнгөтнүүдийг урамшуулан зоригжуулагч хөшүүрэг болж байжээ. Хятад-японы дайнд ялагдсаны дараахан (1895) шинэчлэх хөдөлгөөний гол үзэл сурталчид Кан Ювэй, Лян Цичао, Мао Шэнхуа нар эзэн хаандаа меморандум бичиг өргөж тэдний дэвшүүлж байгаа өөрчлөлтийг хэрэгжүүлбэл Хятад орон дэлхий дээр хамгийн хүчирхэг улс болж, Японд булаагдсан Лю Цзю (Рю-Кю) арлыг эгүүлж авахаар барахгүй, Өмнөд далайн бүх орныг эрхшээлдээ оруулж чадна гэж батлан илэрхийлж байжээ. «Хятад нь 400 буюу 500 сая хүн амтай юм. Түүнээс; 10 сая цэрэг татаж болно. Хятадад төмөр болон бусад метал хязгааргүй их учраас түүгээр олон мянган байлдааны хөлөг онгоц үйлдэж болно. Тэгвэл бид таван тивийг байлдан дагуулж шар луутай туг маань газар сайгүй намирч байх болно» гэж Кан Ювэй бичиж байжээ. Кан Ювэй «Да тун» («аугаа их нэгдэл») гэдэг төлөвлөгөөгөө хэрэгжүүлснээр Хятад орон хүчирхэг цэрэг армитай болж газар сайгүй жанжилж чадна гэж үзэж байсныг түүний шавь Лян Цичао баталж байжээ. Лян Цичао өөрөө шунахайран эзлэх үзэл санааг сурталчлах талаар багшаасаа илүү юү гэхээс дутуугүй байжээ. «Манай өвөг дээдэс хамаг хүчээ таван мянган жил тасралтгүй зориулсан бас аугаа их үйлс бий юм... Түүнийг би хятад үндэстнийг өргөжүүлэх үйлс гэж нэрлэж байна. Манай хятад үндэстэн анх эхлээд Шаньдун, Хэнань хоёрхонд нутагладаг хэдхэн жижиг овог аймаг байв. Тэд хэдэн мянган жилийн дотор өсөн өссөөр аугаа их үндэстэн болтлоо олширч лут хүчирхэг том улс байгуулсан билээ. Тэд хоёр замаар өссөн бөгөөд нэгдэх нь манай хилийн дотор, гадна оршигч олон үндэстэн ястныг уусгах зам байв. Хоёр дахь нь манай үндэсний хүмүүсийн жилээс жилд зах хязгаарын нутагт нүүлгэн суулгаж газар нутгаа тэлж өргөжүүлэх зам байв» гэж бичиж байжээ. Ийнхүү хятадын хөрөнгөтнөөс империалист гүрний колоничлолыг эсэргүүцэх үзэл нь феодалын уламжлалт милитарист үзэл санааны нөлөөгөөр аажимдаа шовинист үзэл болон хувирч байжээ.

Гэвч тэрхүү харгис балмад санаархлаа хэрэгжүүлэх чадал бололцоо эдийн засгийн хувьд дорой, улс төрийн хувьд тархай хятадын хөрөнгөтнүүдэд байгаагүй юм. Тэд засгийн эрхэнд байхдаа ч гэсэн өрнөдийн орнуудын монополист капиталын эрх ашгийн эсрэг дорвитой үг ч дуугарч чадаагүй билээ. Тэглээ ч гэсэн гоминьданы засгийн газар айл хөрш орнуудын төрийн бүрэн эрх, дотоод хэрэгт нь хөндлөнгөөс оролцох гэж нэг бус удаа оролцож байсныг монголын ард түмэн ч сайн мэднэ. Тэгээд ч Бүгд Найрамдах Ардчилсан Вьетнам улсын хувьсгалт түр засгийн газар үүсч байгуулагдсан 1945 оны наймдугаар сарын 28-нд Холбоотны цэргийн командлалын даалгавраар япон цэргийн зэвсгийг хураах нэрийдлээр хятадын дөрвөн арми (200 мянга орчим цэрэг) Вьетнамын хилд цөмрөн оржээ. Гэтэл хятадын цэрэг нь БНАВУ-ын байдлыг өөрчилж, тэнд гоминьданы маягийн дэглэм тогтоох зорилгоор Хятадад орогнож байсан хөлсний этгээд вьетнамын «Куок зан данг», «Донг минь хой» хэмээх националист намуудын удирдагчдыг дагуулж очсон байжээ. Хятадын цэргийн

командлал газар дээрээ очоод японы 48 мянган цэргийн зэвсгийг хураахын оронд харин вьетнамын орон нутгийн засаг захиргааны байгууллагад өөрсдийн талын этгээдийг шургуулах арга хэмжээ авч, БНАВУ-ын хууль ёсны засгийн газрыг хятадын талыг баримтлагч дэглэмээр солих бэлтгэлийг нууцгай хийж байжээ. Түүгээр үл барам гоминьданы эрх баригчид өөрсдийн талын хүмүүсийг бэхжиж суурьштал Вьетнамын умард хэсгийг эзэгнэж суух бодолтой байжээ. Гэвч Холбоотон гүрнүүд тийм бололцоо өгөөгүй учраас гоминьданы засгийн газар Вьетнамаас цэргээ арга буюу татахад хүрчээ.

Х Х Х

Бараг хоёр мянгаад жилийг хамарсан энэ бүх түүхийн баримт нь Хятадын эрх баригчид хэзээнээс нааш Вьетнамын талаар гагцхүү эзлэн залгих, эрх чөлөө, үндэсний тусгаар тогтнолоо юу юунаас чухалчлан эрхэмлэдэг энэ ард түмнийг уусган арилгах бодлого баримталж ирснийг тодорхой харуулж байна. Энэ бүхэн бол ганц вьетнам төдийгүй ерөөсөө айл хөрш бүх улс үндэстний талаар хятадын эрх баригчдын ийм санаа бодол өвөрлөж ирсэн, өвөрлөсөөр байгааг харуулж байна. Хятадад ямар ч засаг төр байлаа гэсэн тэдний удирдагчид нь айл хөрш орнуудыг Хятадад захирагдаж байвал зохих тавилан бүхий боол зарц нар мэт үзэж, дайн түрэмгийллийг Хятадын газар нутгийг тэлж өргөжүүлэх, «Дундат иргэн улсын» ноёрхлыг газар сайгүй тогтоох ганц арга гэж үзэж байдаг нь ч харагдаж байна. Түүнчлэн аль ч үед бусад улс орныг айлган сүрдүүлэх, шахалт даралт үзүүлэх, өнгө мөнгөөр зулгуудах хутган үймүүлэх, дотоод хэрэгт нь хөндлөнгөөс бүдүүлгээр оролцох, эцсийн эцэст «залхааж хашраах», «номхотгон тохинуулах» нэрээр түрэмгийлэн орж хүн ардыг нь алж хядах, эд баялгийг тонон дээрэмдэх явдал хятадын бүх үеийн эрх баригчдын гол нэг арга болсоор иржээ.

Түрэмгийлэн эзэлж, жанжлан ноёрхох тэр эрмэлзлэл, хар санаат зальхай балмад арга барил нь Бээжингийн одоогийн эрх баригчдын гадаад бодлогын үйл ажиллагааны салшгүй гол агуулга болж байна. Чухамдаа Бээжингийн одоогийн удирдагчид нь Хятад орон шинжлэх ухаан-техник, нийгэм-эдийн засаг, улс төр-соёлын талаар хоцрогдмол бас харийн империалист колоничлогчид тус орныг хуваан эзлэх бодлого явуулж байсны улмаас урьд хятадын үндэсний хөрөнгөтнүүдийн хэрэгжүүлж чадаагүй шунахай санаархлыг өвлөн үргэлжлүүлж байна. Нэг үгээр хэлэхэд Хятадыг өөрийн бодлого эрмэлзлэлээ бусад орнуудад тулган хүлээлгэж чадахуйц тийм цэрэг-улс төрийн хүч нөлөөтэй хэт их гүрэн болгон хувиргаж, эцсийн эцэст Хятадын ноёрхлыг дэлхий дахинд тогтоох цорын ганц стратегийн зорилго Хятадын эзэн хаад, үндэсний хөрөнгөтөн, цэргийн эрхтэн, хуучин, шинэ маоистуудыг холбон нэгтгэж байна. Үүний тодорхой илрэл бол Социалист Вьетнамын эсрэг өдүүлсэн түрэмгий дайн, дайны гал зогссоноос хойш тасралтгүй, тэр ч байтугай улам бүр өргөжин буй янз бүрийн зэвсэгт өдөөн хатгалга, бузар муухай гүтгэлэг, империалистууд болон бусад харгис хүчинтэй хуйвалдах замаар Вьетнамд үзүүлж буй шахалт даралт, Ардчилсан Лаос, Кампучийн дотоод хэрэгт хөндлөнгөөс бүдүүлгээр оролцон тэдгээр орны төрийн бүрэн эрх, тусгаар тогтнолд шууд заналхийлж байгаа явдал юм. Яагаад хятадын эрх баригчид Вьетнамыг ингэж уулгалан дайрч, түүнд аль болох их хор хөнөөл учруулах гэж улайран тэмцэж байна вэ? Үүний шалтгаан тодорхой юм.

Нэгдүгээрт, Зүүн өмнөд Азийн орнуудын ард түмний үндэсний эрх чөлөөний олон зуун жилийн тэмцлийн үр шимийг жанжлан ноёрхох зорилгодоо ашиглаж, тэдгээр орныг Бээжингийн дуулгавартай зарц болгох гэсэн их хан үндэстний дээрэнгүй бодлого явууллагыг Вьетнамын Коммунист Нам, Социалист Вьетнамын засгийн газар, ард түмэн тас цохилоо.

Хоёрдугаарт, Нэгдмэл хүчирхэг Вьетнам улс үүсч Азийн энэ бүсэд социализмын эрх ашгийг тууштай хамгаалж байгаа нь Зүүн өмнөд Азийг Ази болон Номхон далайн районыг түрэмгийлэн эзлэх гишгүүр болгох гэсэн бээжингийн жанжлах үзэлтнүүдийн хэрцгий санаархалд хүчтэй хориг саад болж байна.

Гуравдугаарт, Кампучийн ард түмэн Пол Пот-Иенг Сарийн фашист яргачдын дэглэмийг ах дүү вьетнамын интернанионалч тусламж дэмжлэгтэйгээр эрх чөлөөт гэгээн саруул замдаа орсон явдал харгис маоизмын онол, практикийг Кампучид экспортлон нэвтрүүлсний хамаг бүх гэмт ул мөрийг дэлхий дахинд илчилж өглөө.

Дөрөвдүгээрт, Социалист Вьетнамыг олон жилийн дайны хүнд хэцүү уршгаас ангижирч амжаагүй дээр нь бут цохих гэсэн Бээжингийн түрэмгий үйлдэл шившигтэй ялагдал хүлээж, харин дэлхийн социалист систем дэвшилт олон нийтийн, халуун дэмжлэг тусалцааг хүлээсэн Вьетнам орон ялагдашгүйг харуулав.

Байдал ийм болмогц Бээжингийнхэн одоо хятад-вьетнамын харилцааг цаг үргэлж хурацатгаж, Вьетнамын социалист бүтээн байгуулалтын хурдцад саад тотгор учруулах, тэр орны болон түүний анги зорилго нэгт ах дүү социалист орнуудын хүч анхаарлыг улс ардын аж ахуйгаа хөгжүүлэх, хөдөлмөрчин олон түмнийхээ аж байдлыг байнга дээшлүүлэх, социалист, коммунист байгуулалтын үндсэн зорилтоос хөндийрүүлэхийг махран оролдож байна.

Гэвч «санаа муут яван хатна» гэдэг ардын цэцэн үгийн ёсоор ард түмний эрх ашгийн эсрэг тэмцэгч бүхэн хэзээ ч ялагддагийг түүх сургаж байна.

Д. Базаргарьд

ПАГУБНАЯ ТРАДИЦИЯ КИТАЙСКО АГРЕССИИ

Р е з ю м е

В статье дается краткий исторический обзор военных агрессий Китая против Вьетнама в прошлом и настоящем, вызванных традиционной внешнеполитической доктриной Китая, основанной на реакционных принципах синоцентризма и феодальных экспансионистских категориях о данниках и вассалах.

По подсчетам вьетнамских историков (до 1979 г.) за 2200 лет вьетнамский народ вел 13 войн против чужеземных агрессоров, из которых 9 против китайских захватчиков. Как отмечается в статье, в период господства Цинь (221—906 до н. э.) его императором Цинь Шихуаном было положено начало аннексионистской политике Китая в отношении Вьетнама.

Автор подчеркивает тот факт, что вьетнамский народ каждый раз решительно вставал на защиту своей родины и свободы от чужеземных поработителей и, мужественно отражая вражеские нашествия, неоднократно провозглашал независимость своей страны.

Неизгладимым героизмом занесены в историю вьетнамского народа имена сестер-патриоток Чынг Чак и Чынг Ньи, возглавлявших борьбу против нашествия ханьского императора У Ди. Агрессивные войны, спровоцированные китайскими агрессорами, продолжались и в период Суньской

и последующих династий Китая. Богатство недр Вьетнама и выход в море всегда привлекали к себе внимание китайских гегемонистов и милитаристов, которые рассматривали страны Индокитая как трамплин для развертывания захватнических походов против стран всей Восточной и Южной Азии. Характерно то, что при всем этом китайские милитаристы сочетали свои агрессивные войны с тактикой «подавить одного варвара руками другого». В этом автор видит прямую перекличку сегодняшней политики Пекина с политикой великоханьских экспансионистов в прошлом. Китайская агрессия как обычно сопровождалась тяжкими репрессиями, разорениями и всякого рода издевательствами над невинным населением Вьетнама. Хотя все это происходило более тысячу лет назад, события 1979 г., пишет автор, сильно напоминают их в деталях.

В период Миньской династии Вьетнам неоднократно становился объектом агрессии и в XVII—XVIII вв. также подвергался агрессии со стороны захватчиков Цинского Китая. Цинский император, Канси, в частности, рассматривал Вьетнам как «вассал», а себя считал сыном Неба и правителем Вьетнама.

В конце XVIII в. в результате крестьянского восстания, охватившего всю страну, на вьетнамской земле было создано единое крупное государство с мощной армией. Образование сильного Вьетнамского государства с самостоятельной политикой, вызвало опасение у правителей Китая. В 1788 г. император Цянь Лун послал свое 200-тысячное войско по четырем направлениям: Ланшон, Каобанг, Гуанинь и Тюенкуан. Но встретившись с героическим сопротивлением вьетнамцев, китайская армия потерпела поражение у современного Ханоя.

В заключение автор отмечает, что уроки истории поучительны и нужно считаться с ними. Нынешние агрессивные действия Пекина против единого социалистического Вьетнама заранее обречены на провал.